



**ЗООНОЗЫН ӨВЧИН СУДЛАЛЫН  
ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ЗАХИРЛЫН  
ТУШААЛ**

2023 оны 04 сарын 12 өдөр

Дугаар A/22

Улаанбаатар хот

**Зардал батлах тухай**

Монгол Улсын Засгийн Газрын 2022 оны 03 дугаар сарын 09-ний өдрийн 107 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1, 16.5.5 дахь заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын санхүүжилтээр хэрэгжих “Ковид-19 халдвар болон зоонозын халдвараас сэргийлэх эмийн бус эмчилгээний аргын талаар мэдээлэл сурталчилгааг зохион байгуулах” ажлыг батлагдсан удирдамжийн дагуу чанартай гүйцэтгэж ажиллахыг Захиргааны албаны Гадаад харилцаа, төсөл хариуцсан мэргэжилтэн (Б.Уянга)-д үүрэг болгосугай.

2. Төсөлт ажлын зардал болох 25,866,000 (Хорин таван сая найман зуун жаран зургаан мянга) төгрөгийг холбогдох зардлаас тооцож гаргахыг Ахлах нягтлан бодогч (З.Ууганцэцэг)-д зөвшөөрсүгэй.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргааны албаны дарга (Г.Дашдаваа)-д даалгасугай.

ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ



Н.ЦОГБАДРАХ